



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/14

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Ц.Батсайхан	-Шүүхийн шинжилгээний албаны дарга, цагдаагийн дэд хурандаа
Нарийн бичгийн Дарга:	Ж.Ариунзаяа	-Шүүхийн шинжилгээний албаны эмч, цагдаагийн ахлах дэслэгч
Гишүүд:	Б.Алтансүвд	-Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Цэцэгсүрэн	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн


2. Шүүхийн шинжилгээний албаны шүүх эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх гэрээнд тусгагдсан тоног төхөөрөмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Ц.Батсайхан/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

3 062



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН АКТ

201... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дугаар.....

.....хот/аймаг

НЭГ.

1.1 Гэрээний нэр, дугаар, огноо.....

1.2 Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал.....

1.3 Захиалагч байгууллага.....

1.4 Гүйцэтгэгч байгууллага.....

1.5-ийн оны дугаар сарын-ны өдрийн
.....тоот тушаалаар томилогдсон хүний бүрэлдэхүүнтэй Тоног
төхөөрөмж хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд
байгуулсан тоот гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг
гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг
хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон
тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудтай газар дээр нь танилцаж, шалган
үзэв.

1.6 Тоног төхөөрөмжийг оны ... дугаар сарын ... -ны өдөр бүрэн нийлүүлж
дууссан байна.

ХОЁР.

2.1 Тоног төхөөрөмжийг шалгаж үзээд, гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу
нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ
биелүүлсэн гэж үзлээ.

2.2 Тоног төхөөрөмжийг захиалагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлж,
ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

2.3 Тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт, холбогдох баримт бичиг,
материалыг 4 хувь үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч, төсвийн асуудал эрхэлсэн
төрийн захиргааны байгууллага тус бүрт 1 хувийг хүргүүлнэ.


2.4 Энэ актаар хүлээн авсан тоног төхөөрөмжийн бүх баримт бичиг нь дараах
зүйлээс бүрдэнэ. Үүнд:

а) Тоног төхөөрөмжийг дагалдах техникийн бусад баримт материал

б) Баталгаат засварын хугацаа, бичиг баримт:

в/ Бусад

ГУРАВ.



№	Нэр төрөл	Марк	Үйлдвэрлэсэн улс, байгууллага, огноо	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Тээвэрлэлтийн үнэ /шаардлагатай бол бөөлөх/	Угсралт туршилтын үнэ /шаардлагатай бол бөөлөх/	Нийт үнэ
1	Ротари Микротом		Тайвань улс, 2010 он	1 ширхэг				
2	Микротомын хутга баригч		Тайвань улс	1 ширхэг				
3	Микротомын хутга		Герман улс, 2012 он	50ш x 2				
4	Эдийн болон эсийн шилэн бэлдэц хадгалах шүүгээ		Хятад улс, 2013 он	1 ширхэг				
5	Будгийн дамжлагын шилэн сав		Оросын холбооны улс	1 иж бүрдэл/12 ширхэг шилэн сав/				
6	Эдийн дамжлагын торхонцор цуваа		Оросын холбооны улс	1 иж бүрдэл/12 ширхэг шилэн сав/				
7	Эдийн дамжлагын торхонцор цуваа		Япон улс, 2010 он	100 ширхэг				
8	Зүслэгийн багажны ком			1 иж бүрдэл				
9	Термостат		Оросын холбооны улс	1 ширхэг				
10	Хөргөгч		Тайвань улс	1 ширхэг				
11	Парафин		Солонгос улс	5 кг				
12	Гематоксилин будаг		Герман улс	1 литр				
13	Эозин будаг		Герман улс	1 литр				
14	Бальзим		Канад, Солонгос улс	1 литр				
15	Тавиур шил		Герман улс	500 ширхэг				
16	Бүрхүүл шил		Канад, Солонгос улс	500 ширхэг				
Дүн								



Тоног төхөөрөмж хүлээн авсан:

Комиссын дарга:...../Гарын үсэг, тамга тэмдэг, огноо/

Нарийн бичгийн дарга:...../Гарын үсэг, тамга тэмдэг, огноо/

Гишүүд:...../Гарынүсэг, тамга тэмдэг, огноо/

Гишүүд:...../Гарынүсэг, тамга тэмдэг, огноо/

Гишүүд:...../Гарынүсэг, тамга тэмдэг, огноо/

Тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн:

/Энхийн эрэлд" ХХК/